



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

539. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай 2022

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

540. $\text{Ä}^{\circ}\text{ï}^{\text{d}}\text{e}^{\text{e}}\text{e}^{\circ}\text{ã}^{\text{d}}\text{e}^{\text{e}}\text{í}^{\text{d}}\text{ï}^{\text{d}}\text{e}^{\text{a}}\text{e}^{\text{e}}\text{í}^{\text{d}}\text{ö}^{\text{b}}\text{ö}^{\text{a}}\text{e}$ Дугаар 24 2024

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

541. Номын баярын өдөр тэмдэглэх тухай Дугаар 158 2025

542. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 162 2026

543. Албан тушаалаас чөлөөлөх, албан тушаалд томилох тухай Дугаар 163 2026

544. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн чөлөөлөх, томилох тухай Дугаар 164 2027

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

545. Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай Дугаар 234 2027

546. Гал унтраах анги байгуулах тухай Дугаар 250 2029

547. Хөтөлбөр батлах тухай Дугаар 252 2030

548. Ойн талбайн норматив, байршил батлах тухай Дугаар 255 2047

549. Тэмцээн зохион байгуулах тухай Дугаар 261 2048

550. Монголын Оюутны спортын III их наадам зохион байгуулах тухай Дугаар 262 2049

551. Журам батлах тухай, тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 263 2050



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 09 дүгээр
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэний даатгуулагч өөрөө төлөх 10 хувийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлүүлэн нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөнд тооцуулах асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль тогтоомж

2.1.Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хөдөлмөрийн тухай², Нийгмийн даатгалын тухай³, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох” гэж нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний 1990-1995 оны хооронд ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэний даатгуулагч өөрөө төлөх 10 хувийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлүүлэн нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөнд тооцуулах ажиллагааг.

¹Монгол Улсын Үндсэн хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Хөдөлмөрийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

³Нийгмийн даатгалын тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн

⁴Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль- “Төрийн мэдээлэл”эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн



4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хуулийн үйлчлэлд 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан дараах иргэн хамаарна:

4.1.1. аж ахуйн нэгж, байгууллага нь Иргэний хуулийн⁵ 32 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буугдсаны улмаас ажилгүй болсон;

4.1.2. аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн байгуулагдсаны улмаас орон тооны цомхотголд орсон;

4.1.3. өөрөөс үл хамаарах шалтгаанаар ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан;

4.1.4. мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд нь тухайн ажил, албан тушаалд тэнцэхгүй болсны улмаас ажлаас халагдсан.

5 дугаар зүйл. Тэтгэврийн даатгалыг нөхөн тооцох шимтгэлийн хувь хэмжээ

5.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан иргэний сард нөхөн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиар тогтооно.

6 дугаар зүйл. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох

6.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан иргэний ажилласан хугацааг нөхөн тооцох, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх ажлыг нийгмийн даатгалын төв байгууллага зохион байгуулж гүйцэтгэнэ.

6.2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан иргэний нэгдсэн бүртгэл, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төвлөрүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлтэй зөвшилцөн батална.

⁵Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн



7 дугаар зүйл.Бүрдүүлэх баримт бичиг

7.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан иргэн дараах баримт бичгийн аль нэгийг бүрдүүлнэ:

7.1.1.хууль тогтоомжид заасан журмын дагуу хөтөлсөн хөдөлмөрийн дэвтрийн хуулбар;

7.1.2.1990-1995,1995-2000 онуудад оршин сууж байсан газрынхаа харьяалах аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;

7.1.3.ажилласан хугацааг нь тооцох баримтгүй болсон иргэний ажилласан хугацааг шүүхээс тогтоосон бол уг шүүхийн шийдвэр.

7.2.Ажилласан хугацааг нөхөн тооцуулах, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөхийг хүссэн иргэн өргөдлөө энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийн хамт аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтэст өгнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурал 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр баталсан Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Номын баярын өдөр тэмдэглэх тухай

Монгол туургатны мянганаар тоологдох өв их соёл, язгуур уламжлалын магнайд ном эрдмийг хүндэтгэн дээдэлж есөн эрдэнээр чимэглэн, шасдир их цадиг, суу сэтгэлгээний охь болсон бүтээлүүдээ нандигнан хайрлаж, ном дор мөргөхийг сүслэн, эрхэмлэн уншдаг ариун ёс, уламжлал бий.

Эдүгээ энэ сайхан уламжлал хэвээр хадгалагдаж буй бөгөөд Монгол орны хөгжил дэвшил, өөдрөг гэгээн ирээдүй чухамхүү эрүүл бие, саруул ухаантай, эрдэм боловсролд тэмүүлсэн Монгол хүнээс шалтгаалах буюу.

Уламжлалт зан заншлаа хөгжүүлж, ард иргэд, хүүхэд залуусын ном эрдэмд эгээрэн нөхөрлөх хандлагыг улам бүр дэмжих зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Жил бүрийн 9 дүгээр сарын гурав дахь долоо хоногийн Бямба гарагийг “Номын баярын өдөр” болгон өргөнөөр ёслон тэмдэглэсүгэй.

2. Номын баярын өдрийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд:

а) Улаанбаатар хотын дүүргүүд, бүх аймаг, сумдад хүүхэд, залуучууд, ард иргэдийг өргөнөөр оролцуулсан ёслолын ажиллагаа зохион байгуулж, хэвлэмэл болон сонсдог, дижитал буюу тоон технологид суурилсан номын үзэсгэлэн худалдаа гаргах, ном солилцох, бэлэглэх, хандивлах.

б) Шилдэг ном шалгаруулах, номын зохиогчийг алдаршуулах, сайн уншигчийг тодруулах ажиллагаа явуулах, зохиолч уншигчдын уулзалт ярилцлага хийх, уламжлалаа сэргээж “Номын сайн нөхөр” тэмдэгтэнг олноор төрүүлэх, тэднийг сургууль, анги, хамт олон нь зүйл бүрээр хөхиүлэн дэмжих, хэвлэл мэдээллээр сурталчлах.

в) Аймаг, сум, тосгонд ном унших нийтийн танхим, номын сан байгуулж тохижуулах.

3. Номын баярын өдөр бүх нийтээр ном эрдмийг сурталчлах, номын өв санг арвижуулах, хүүхэд залуучуудын сурах эрмэлзэлд дэмжлэг



үзүүлэн ажиллахыг Монгол Улсын нийт ард иргэд, эцэг эх, багш, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжид уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Шри Ланка Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ворошиловын Энхболдыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Социалист Шри Ланка Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Санжаасүрэнгийн Баярааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар
хот

**Албан тушаалаас чөлөөлөх,
албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар батлагдсан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жигмиддашийн Баярцэцэгийг төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөхийн албан тушаалаас чөлөөлж, Чадраабалын Өнөрбаярыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөхийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар
хот

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн чөлөөлөх, томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2, 61.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Пунцагийн Цагааныг Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлж, Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Чадраабалын Өнөрбаярыг Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар
хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16.3, 16.4 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийг хэмжил зүйгээр дэмжих, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах ажлыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий “Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД



Засгийн газрын 2012 оны 234 дүгээр
тогтоолын хавсралт

ХЭМЖИЛ ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

-Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга

Гишүүд:

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
газрын дарга;

-Батлан хамгаалах яамны Мэдээлэл, хяналт-
шинжилгээ, үнэлгээний газрын дарга;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын
яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын
дарга;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын
газрын дарга;

-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим
хүчний бодлогын газрын дарга;

-Эрүүл мэндийн яамны Стратегийн бодлого,
төлөвлөлтийн газрын дарга;

-Шинжлэх ухааны академийн Физик,
техникийн хүрээлэнгийн захирал;

-Монгол Улсын Их сургуулийн Мэдээлэл,
технологийн их сургуулийн захирал;

-Шинжлэх ухааны их сургуулийн Эрчим хүч,
инженерийн сургуулийн захирал;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд
бүтцийн хяналтын газрын дарга;

-Стандартчилал, хэмжил зүйн газрын
Эталоны албаны дарга;

-Стандартчилал, хэмжил зүйн газрын
Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын
албаны дарга;



**Нарийн бичгийн
дарга**

-“Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ийн захирал;
-Геологийн төв лабораторийн захирал;
-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн төлөөлөл (тохиролцсоноор);
-Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл (тохиролцсоноор);
-Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл (тохиролцсоноор).
-Стандартчилал, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн хэлтсийн дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар
хот

Гал унтраах анги байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Бэрх тосгонд Гал унтраах III зэрэглэлийн 42 дугаар ангийг байгуулсугай.

2. Шинээр байгуулагдаж байгаа ангийн барилгыг барих хөрөнгийг 2013 оны улсын төсөвт тусган санхүүжүүлж, бусад зардлыг жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан хавсралтын 21 дэх заалтын “Хэнтий аймгийн онцгой байдлын хэлтэс (гал унтраах II зэрэглэлийн 32 дугаар анги, аврах салбартай)” гэсний дараа “Бэрх тосгонд Гал унтраах III зэрэглэлийн 42 дугаар анги” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 252

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийг 1 дүгээр, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн төсөлд тусган зээл, тусламж, төсөлд хамруулан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Д.Хаянхярваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2012 оны 252 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ХӨТӨЛБӨР**

Нэг. Үндэслэл

Хууль, эрх зүйн талаархи мэдлэг, мэдээлэл дутмагаас болж иргэд гэмт хэргийн золиос болох нь түгээмэл бөгөөд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтыг хангахад гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах, энэ талаар сургалт зохион байгуулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг тэдэнд эзэмшүүлэх явдал чухал ач холбогдолтой юм.



Мөн түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллага, гэр бүл, иргэний оролцоо чухал үүрэгтэй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тэдгээрийн оролцоонд түшиглэн тогтмол явуулах нь зүйтэй юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг иргэдэд эзэмшүүлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг үр өгөөжтэй, ойлгомжтой хэлбэрээр иргэдийн нас, хүйс, сонирхол, онцлогт тохируулан явуулах;

3.1.2. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд мэдээллийн дэвшилтэт техник, технологийг өргөнөөр ашиглаж, шинэлэг хэлбэрээр зохион байгуулах;

3.1.3. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулж, тэдгээрийн ажлын уялдаа холбоог сайжруулах;

3.1.4. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд чанартай, хүртээмжтэй, үр ашигтай зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл

4.1. Хөтөлбөрийг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

4.1.1. архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.2. хар тамхи, мансууруулах бодисын эсрэг тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;



4.1.3. замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.4. хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.5. гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.6. хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.7. байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.8. мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх;

4.1.9. нийгмийн ажилтан, сургагч багш нарыг бэлтгэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1. архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах;

5.1.2. архины хамааралтай хүмүүс болон тэдгээрийн гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

5.1.3. хамт олон, гэр бүлийн хандлагыг өөрчлөх замаар архидалттай тэмцэх, эрүүл аж төрөх ёс, амьдралын зөв хэвшлийг бүрдүүлэхийг бүх талаар дэмжих;

5.1.4. архинд донтох өвчтэй хүмүүсийг сэтгэл заслын аргаар эмчлэх, тэдгээрт зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх төвүүдийг нээн ажиллуулах.

5.2. Хар тамхи, мансууруулах бодисын эсрэг тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1. өсвөр үеийнхний дунд хар тамхи, мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэснээс үүсэх хор уршгийн талаар албан ба албан бус сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;



5.2.2. хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, хор хөнөөлийн талаархи насанд хүрэгчдийн мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгааны ажлыг бүсчлэн хийх;

5.2.3. хэвлэл мэдээллийн хэрэгслийг хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаархи мэдээлэл, сурталчилгааны ажилд өргөнөөр ашиглах, энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах.

5.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1. замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, сахилга хариуцлагыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

5.3.2. жолооч нарт зориулсан албан ба албан бус сургалтыг тогтмол зохион байгуулах;

5.3.3. согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулсан жолооч нарыг албан сургалтад хамруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

5.4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг хүүхдэд олгох мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой хэрэгжүүлэх;

5.4.2. хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг хүүхдийн сэтгэхүйд тохирсон шинэлэг хэлбэрээр зохион байгуулах;

5.4.3. хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургагч багш нарыг бэлтгэх.

5.5. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5.1. гэр бүлийн хүчирхийллийн талаархи иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулах;



5.5.2. гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлдэг эрх зүйн туслалцааны төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах;

5.5.3. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын ажилтныг сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор тогтмол сургалтад хамруулах.

5.6. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.6.1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг иргэдэд сурталчлан таниулах;

5.6.2. хүн худалдаалахтай тэмцэх, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөд өртөхөөс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тодорхой зорилтот бүлгүүдэд зориулан тогтмол зохион байгуулах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

5.6.3. хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтныг сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах арга хэмжээг тогтмол авах.

5.7. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.7.1. өсвөр үе, залуучуудын экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор байгаль орчныг хамгаалах талаар өвөг дээдсээс уламжлагдаж ирсэн үндэсний зан заншлыг сэргээн өвлүүлж, таниулан сурталчлах арга хэмжээ авах;

5.7.2. байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, тэдгээрийн санал, санаачлагыг дэмжин ажиллах;

5.7.3. байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах.

5.8. Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.8.1. мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлын талаар иргэдэд тодорхой мэдлэг, ойлголт өгөх зорилгоор мэдээлэл,



сурталчилгааны ажлыг холбогдох байгууллагуудын оролцоотой зохион байгуулах;

5.8.2. төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд мэдээллийн аюулгүй байдлын талаар цахим сургалтыг зохион байгуулах;

5.8.3. интернэтийн зүй зохистой хэрэглээ болон болзошгүй эрсдэл, аюулын талаар хүүхэд, эцэг, эх болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан сургалт сурталчилгаа явуулах;

5.8.4. мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

5.9. Нийгмийн ажилтан, сургагч багш нарыг бэлтгэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.9.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар зорилтот бүлгүүдэд зориулсан сургалт явуулах сургагч багш, нийгмийн ажилтан бэлтгэх;

5.9.2. сургагч багш, нийгмийн ажилтныг орон нутагт бүсчлэн бэлтгэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

5.9.3. ерөнхий боловсролын сургуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, бүлгэм байгуулах идэвх санаачлагыг дэмжих.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага,
зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хариуцан эрхэлнэ.

6.2. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хариуцан эрхэлнэ.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хяналт тавьж, хөтөлбөрийн үр дүнг хагас жил тутам хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

7.1. Хөтөлбөрийг 2012-2016 онд хэрэгжүүлнэ.



7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.2.1. улсын болон орон нутгийн төсөв;

7.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал;

7.2.3. иргэн, хуулийн этгээдийн хандив;

7.2.4. гадаад улс, олон улсын байгууллагын тусламж, хандив;

7.2.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн
хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж, дүнг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

8.2. Хөтөлбөрийг дараахь үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

8.2.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны хүртээмж, чанар сайжирч, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна;

8.2.2. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, гэр бүлийн оролцоо нэмэгдсэн байна;

8.2.3. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, олон нийтэд хүргэх тогтолцоо бүрдсэн байна;

8.2.4. гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар шинээр батлагдсан хууль, эрх зүйн акт, тэдгээрийн хэрэгжилтийг иргэдэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг шуурхай хүргэдэг тогтолцоо бүрдсэн байна;

8.2.5. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн насны онцлог, сонирхолыг харгалзсан, зорилтот бүлгүүдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулснаар түүний чанар, хүртээмж, үр нөлөө нь дээшилсэн байна.

Засгийн газрын 2012 оны 252 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

“ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ
ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Урьдчилсан байдлаар тооцсон төсөв (сая.төг)
1. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:				
1.1	Оюутан, сурагчдын дунд байгаа архинаас үүдэлтэй гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар холбогдох байгууллагатай хамтран судалгаа хийх, судалгааны үр дүнд суурилан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах		2013 оны II улирал	ХЗДХЯ, БСШУЯ, ЦЕГ -
1.2	Архинд донтох өвчтэй хүмүүст зориулан архины хор хөнөөлийн талаар сургалт явуулах, тэднийг нийгэмшүүлэх зорилгоор мэргэжлийн сургалтад (үсчин гоо сайхан, мужаан, гар урлал зэрэг) хамруулах арга хэмжээ авах		2013-2014 он	ГХУСАЗЗ, Архидалт мансуурлын эсрэг ассоциаци -
1.3	Архинд донтох өвчтэй хүмүүст сэтгэл зүйн болон ганцаарчилсан зөвлөгөө өгөх төвийг Дундговь, Өмнөговь, Дорноговь, Увс, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай аймагт нээн ажиллуулах		2013-2014 он	ГХУСАЗЗ, Архидалт мансуурлын эсрэг ассоциаци -
1.4	Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны цахим мэдээллийн санг боловсронгуй болгож мэдээлэл, сургалт, сурталчилгаанд өргөнөөр ашиглахаас гадна онлайн сүлжээгээр зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэх		2013-2016 он	ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ТББ 8.0



1.5	Архи, тамхигүй орчинг бүрдүүлсэн байгууллага, хамт олныг шалгаруулан урамшуулах, тэдний туршлагыг нийтэд сурталчлах	2013-2016 он	ХЗДХЯ, БСШУЯ, НХХЯ, ГХУСАЗЗ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ	-
1.6	Жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоногийн Бямба гарагт "Архи, тамхигүй ирээдүй" сэдэвт биеийн тамир, спортын арга хэмжээг оюутан, залуусын дунд зохион байгуулах	2013-2016 он	ХЗДХЯ, БСШУЯ, ЭМЯ, ГХУСАЗЗ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД	30.0
2. Хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:				
2.1	Хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг, аюулын талаар мэдлэг олгох хичээлийг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах, түүнтэй тэмцэх хүүхдийн сайн дурын бүлгэм байгуулах ажлыг сургуулийн захиргаа, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	2013-2016 он	БСШУЯ, ХЗДХЯ, ЭМЯ, ЦЕГ, ХТГ	-
2.2	Цахим сүлжээ (facebook, twitter)-г ашиглан хар тамхи, мансууруулах бодисоос хүүхэд, залуучуудыг сэрэмжлүүлэх зорилго бүхий оюутан, залуусын сүлжээ байгуулах, түүгээр дамжуулан сургалт, сурталчилгаа явуулах, сүлжээнд хамрагдсан хүүхэд, залуусын санал, санаачлагыг дэмжиж ажиллах	2013-2016 он	ХЗДХЯ, ГХУСАЗЗ, МШХХТГ, МЗХ, ТББ	-

<p>2.3 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаархи мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, нэвтрүүлэх, богино хэмжээний сурталчилгааг бэлтгэн явуулах</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ, ГЕГ, ТЕГ, Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд</p>	<p>2012-2016 он</p>	<p>20.0</p>
<p>2.4 “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгээр хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар 10 минутын нэвтрүүлэг бэлтгэн явуулах (жилд 10 нэвтрүүлэг бэлтгэх)</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ</p>	<p>2013-2016 он</p>	<p>-</p>
<p>2.5 Хил, гаалийн байгууллагын албан хаагчдын дунд хар тамхи, мансууруулах бодисын талаархи сургалтыг жил тутам зохион байгуулах, тэднийг гарын авлага, сургалтын материалаар хангах</p>	<p>ХЗДХЯ, ХХЕГ, ГИХАЭГ, ЦЕГ, ЭЦГ, ТББ</p>	<p>2013-2016 он</p>	<p>20.0</p>
<p>2.6 Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, хор хөнөөлийн талаархи насанд хүрэгчдийн мэдлэгийн түвшинг тогтоох судалгааг Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Увс, Сэлэнгэ, Ховд, Төв, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймгуудыг хамруулан хийх</p>	<p>ХЗДХЯ, ХЗҮХ, ГХУСАЗЗ, Архидалт мансуурлын эсрэг ассоциаци</p>	<p>2013 оны I улирал</p>	<p>40.0</p>
<p>2.7 Хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг, аюулын талаархи санамж, сэрэмжлүүлийг бэлтгэж, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтран гадаадад зорчиж байгаа иргэдэд зориулан тараах</p>	<p>ХЗДХЯ, ГХЯ, ДТГ, ХХЕГ, ГХУСАЗЗ</p>	<p>2013-2016 он</p>	<p>25.0</p>



<p>2.8 Үүрэн телефоны оператор компаниудтай хамтран хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар улирал бүр иргэдэд хандан сэрэмжлүүлэг илгээх</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД, ГХУСАЗЗ</p>	<p>2013-2015 он</p>	<p>20.0</p>
<p>3. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:</p>			
<p>3.1 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор FM 96.3, "Stop" теле студитэй хамтран сэрэмжлүүлэг, теле сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж явуулах</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЗЦГ</p>	<p>2013-2016 он</p>	<p>25.0</p>
<p>3.2 Сотуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулсан жолооч нарыг хууль, сэтгэл зүй, эрүүл мэндийн чиглэлээр сургалтад хамруулах ажлыг төрийн бус байгууллагатай хамтран тогтмол явуулах</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЗЦГ, ТББ, Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд</p>	<p>2013-2016 он</p>	<p>15.0</p>
<p>3.3 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд www.stop.mn цахим хуудсаар дамжуулан мэдээлэл, сургалт сурталчилгааг олон нийтэд хүргэх, иргэд, олон нийтийн санал, хүсэлтийг уг цахим шуудантаар дамжуулж авах</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЗЦГ, улсын төсөв</p>	<p>2013-2016 он</p>	<p>10.0</p>
<p>3.4 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зам, тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмол явуулах</p>	<p>БСШУЯ, ЗЦГ, ГХУСАЗЗ</p>	<p>2013-2016 он</p>	<p>10.0</p>

<p>Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>2013-2016 он</p>	<p>ХЗДХЯ, ЗЦГ, ГХУСАЗЗ, Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд</p>	<p>5.0</p>
<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, нийгмийн ажилтныг замын хөдөлгөөний дүрмийн хичээл заах сургалтч багшаар бэлтгэх</p>	<p>2013 оны II улирал</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ЗЦГ</p>	<p>10.0</p>
<p>4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:</p>			
<p>Эцэг, эх, гэр бүлийн зүгээс хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулах, тэдэнд зөв үлгэр дууриал үзүүлэх хандлагыг сурталчилсан цуврал телевизийн нэвтрүүлэг бэлтгэн, олон нийтийн болон бусад телевизээр нэвтрүүлэх</p>	<p>2013 оны II улирал</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ХТГ</p>	<p>15.0</p>
<p>Хүүхэд, өсвөр үеийнхэн чөлөөт цагаа зөв, боловсон өнгөрүүлэх бүлгэм, дугуйлан, секцийг ерөнхий боловсролын сургуулиудад байгуулахыг дэмжиж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх</p>	<p>2013-2015 он</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ХТГ, Аймаг, нийслэлийн ЗД</p>	<p>15.0</p>
<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр насанд хүрээгүй хүүхдүүдийн дунд хичээлээс гадуур төрөл бүрийн ажил (цуврал хичээл, уулзалт, ярилцлага, мэтгэлцээн, ханын сонин, зурагт хуудасны уралдаан зарлах) зохион байгуулах</p>	<p>2013-2016 он</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСАЗЗ, ХТГ</p>	<p>-</p>
<p>Гэмт хэрэг, зөрчил ихээр гардаг сургуулиудын судалгааг гаргаж, уг судалгаанд үндэслэн зорилготой бүлгүүдэд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах</p>	<p>2013-2015 он</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСАЗЗ, ХТГ, ТББ</p>	<p>20.0</p>



<p>Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн болон ял эдлүүлэхийг хойшлуулсан, хорих байгууллагаас суллагдсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх чиглэлээр уулзалт ярилцлага, сургалт зохион байгуулах, тэдэнд амьдрах арга барил олгох талаар нийгмийн ажилтан, багш нартай хамтарч ажиллах</p>	<p>2013-2015 он</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСАЗЗ, ХТГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ</p>	<p>10.0</p>
<p>Гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртдөг хүүхдүүдийн судалгааг гаргах, хүчирхийллээс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар тэдэнд мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтыг явуулах</p>	<p>2013-2015 он</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ, ХТГ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ</p>	<p>15.0</p>
<p>5. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:</p>			
<p>Эрх зүйн туслалцааны төвийн мэргэжилтэн, өмгөөлөгч нарыг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тэдэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр мэргэшүүлэх</p>	<p>2013 оны III улирал</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ</p>	<p>5.0</p>
<p>Гэр бүлийн хүчирхийллийн талаархи иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэг, эрх зүйн ухаамсрыг дээшлүүлэх, энэ төрлийн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах</p>	<p>2013 он</p>	<p>ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ТББ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв</p>	<p>5.0</p>
<p>Хүний эрх, жендерийн тэгш байдал, хүчирхийлэлгүй аж төрөх харилцааны ур чадвар олгох албан ба албан бус сургалтын хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээг бүх шатны боловсролын байгууллагад зохион байгуулах</p>	<p>2013 он</p>	<p>ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ</p>	<p>5.0</p>

5.4	Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээллийн сүлжээ үүсгэж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглах	2013 он	ХЗДХЯ, ГХУСА33, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	10.0
5.5	Гэр бүлийн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх харилцааг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион явуулах тусгай танхим байгуулах, уг сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу явуулах	2014 он	ХЗДХЯ, ГХУСА33, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	-
6. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:				
6.1	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд (төв, хангай, баруун, зүүн бүсийн аймгуудад) зохион байгуулах	2013-2016 он	ХЗДХЯ, ГХУСА33, Аймаг, нийслэлийн ГХУСА33, ТББ	50.0
6.2	Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран судалгаа хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах	2013-2015 он	ХЗДХЯ, ГХУСА33, ХЗҮХ	10.0
6.3	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулах	2013-2015 он	ХЗДХЯ, ГХУСА33, ЦЕГ, ХХЕГ, ГИХАЭГ, ТББ	15.0
6.4	Цагдаа, хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтан нарт зориулан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гарын авлага, ном бэлтгэн тараах	2012-2016 он	ХЗДХЯ, ГХУСА33	15.0

6.5	Олон нийтийн газар (галт тэрэг, нисэх онгоцны буудал, зочид буудал, зоог, цэнгээний газар)-т хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн сэрэмжлүүлэг бүхий зурагт самбар, хуудас байрлуулах	2013-2016 он	ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ, ТББ	10.0
6.6	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэн, хуулийн этгээд, хамт олныг өргөнөөр гатан оролцуулах, тэдгээртэй хамтран ажиллах, идэвх санаачлагыг нь дэмжиж ажиллах	2013 он	ХЗДХЯ, ГХУСАЗЗ, Аймаг, нийслэлийн ГХУСАЗЗ	10.0
6.7	Хүн худалдаалах болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний сэрэмжлүүлэг бэлтгэж, кинотеатр, бусад хэрэгслийг ашиглан нийтэд хүргэх	2013-2016 он	ХЗДХЯ, ГХУСАЗЗ, НЭДТГ, ЦЕГ, ТББ	10.0
6.8	Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, нөхцөл байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд [У улирал ашиглах	2013 оны [У улирал	ХЗДХЯ	10.0
7. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:				
7.1	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	2013-2016 он	ХЗДХЯ, БОАЖЯ	10.0
7.2	Байгаль хамгаалагч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг орон нутагт зохион байгуулах	2013-2016 он	ХЗДХЯ, БОАЖЯ, Улсын төсөв	10.0

7.3	Байгаль орчныг хамгаалах иргэдийн сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагааг сурталчлах, тэдний үйл ажиллагааг дэмжин урамшуулах	2013-2016 он	ХЗДХЯ, БОАЖЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ	-
7.4	Хүүхэд, залуучуудад зориулсан байгаль орчныг хамгаалах сэдэвт богино хэмжээний хичээл, зохиомжийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх	2013 оны III улирал	ХЗДХЯ, БОАЖЯ, Улсын төсөв	2.0
7.5	Байгаль орчныг хамгаалах талаар үндэсний зан заншлыг сэргээх, хүүхэд, өсвөр үе, залуучуудын экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх	2013-2016 он	БСШУЯ, БОАЖЯ, ХТГ, ТББ	-
7.6	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ авах, ажилтнуудыг нь сургаж чадавхижуулах	2013-2016 он	БОАЖЯ, ТББ	5.0
8. Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд:				
8.1	Мэдээллийн аюулгүй байдлын талаар телевизийн нэвтрүүлэг бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, нийтлэл, хэвлэмэл хуудас хэвлэж олон нийтэд тараах	2013-2015 он	ХЗДХЯ, ГХУСАЗЗ, МШХХТГ	20.0



8.2	Мэдээллийн аюулгүй байдлын талаархи ойлголт, мэдлэгийг нь дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сурагчид болон их, дээд сургуулийн оюутнуудын дунд сургалт явуулах	2013-2014 он	ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСА33, МШХХТГ	20.0
8.3	Мэдээллийн аюулгүй байдлын талаар жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ойлголт, мэдлэг олгох зорилгоор сургалт явуулах	2013 он	ХЗДХЯ, ГХУСА33, МШХХТГ	15.0
8.4	Интернэтийн зүй зохистой хэрэглээ болон болзошгүй эрсдэл, аюулын талаар хүүхэд, эцэг, эх болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан сургалт, сурталчилгаа явуулах	2013-2014 он	ХЗДХЯ, БСШУЯ, ГХУСА33, МШХХТГ	10.0
8.5	Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан түүнээс урьдчилан сэргийлэх санал, дүгнэлтийг боловсруулах Ажлын хэсэг байгуулан ажиллуулах	2013 он	ХЗДХЯ, ТЕГ, МШХХТГ, ДХИСургууль	5.0
9. Нийгмийн ажилтан, сургагч багш нарыг бэлтгэх хүрээнд:				
9.1	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр өсвөр үеийнхэн болон бусад зорилтот бүлгүүдэд сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэх, тэдгээрийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах	2013-2016 он	ХЗДХЯ, БСШУЯ, ХТГ, ТББ	20.0
9.2	Өсвөр үеийнхний дундаас үе тэнгийнхэндээ нөлөөлж, үлгэр дууриал болж чадахуйц сурагчдыг сонгон авч сургагч багшаар бэлтгэх	2013-2016 он	ХЗДХЯ, БСШУЯ, ХТГ, ТББ	10.0
9.3	Ерөнхий боловсролын сургуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, бүлгэм байгуулахыг дэмжиж, түүнд сурагчдыг татан оролцуулах	2013-2016 он	ХЗДХЯ, БСШУЯ, ХТГ, ТББ	-



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 255

Улаанбаатар
хот

Ойн талбайн норматив, байршил батлах тухай

Ойн тухай хуулийн 12.1.5, 14.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлд байгуулагдах сум дундын ойн ангийн хариуцах ойн талбайн норматив, байршлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан нормативыг үндэслэн харьяа нутаг дэвсгэртээ сум дундын ойн ангийг байгуулан орон тооны дээд хязгаар болон дүрмийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж мөрдөх арга хэмжээ авахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Сум дундын ойн ангийн зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймаг нийслэлийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Д.ЦОГТБААТАР

Засгийн газрын 2012 оны 255 дугаар
тогтоолын хавсралт

**ОЙН НӨӨЦ, ТӨЛӨВ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЭРЧИМЖИЛТЭЭС
ХАМААРСАН АЙМАГ, НИЙСЛЭЛД БАЙГУУЛАГДАХ СУМ ДУНДЫН
ОЙН АНГИЙН ХАРИУЦАХ ТАЛБАЙН НОРМАТИВ, БАЙРШИЛ**

№	Ойн муж	Нэг сум дундын ойн ангийн хариуцах ойн талбайн норматив* (мян.га)	Хамрагдах аймаг	Сум дундын ойн ангийн байршил
		901.0-1100.0	Хөвсгөл	Мөрөн
				Жаргалант
				Улаан-Уул
				Цагаан-Үүр



1	Хангайн нурууны ойн аж ахуйн муж	401.0-900.0	Булган	Булган		
				Хангал		
				Хутаг-Өндөр		
			Архангай	Эрдэнэмандал		
				Их тамир		
			Цэнхэр			
			Завхан	Тосонцэнгэл		
				Түдэвтэй		
			Сэлэнгэ	Баруунбүрэн		
				Сүхбаатар		
2	Хэнтийн нурууны ойн аж ахуйн муж	401.0-800.0	Өвөрхангай	Бат-Өлзий*		
			Баянхонгор	Баянхонгор*		
			Увс	Өндөрхангай		
			Төв	Мөнгөнморьт		
			Хэнтий	Биндэр		
			Өмнөдэлгэр			
			Батширээт			
			Сэлэнгэ	Ерөө		
				Мандал*		
			Төв	Батсүмбэр*		
3	Монгол Алтайн ойн аж ахуйн муж	400.0 хүртэл	Дорнод	Баян-Уул*		
			Улаанбаатар	Улаанбаатар*		
			Дархан-Уул	Хонгор*		
			Орхон	Орхон*		
			Ховд	Ховд		
			Баян-Өлгий	Булган		
			Увс	Түргэн		
			Говь-Алтай	Алтай		
		4	Заган ойн аж ахуйн муж	Заган ойн талбай	Өмнөговь	Даланзадгад
					Дорноговь	Сайншанд
Дундговь	Мандалговь					
Сүхбаатар	Баруун-Урт					
Дүн				36		

Тайлбар: *-хүн амын төвлөрөл бүхий ойн сан бүхий сум дундын ойн анги

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 261

Улаанбаатар
хот

Тэмцээн зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 2013 онд олон улсын дараахь тэмцээнийг зохион байгуулахаар тогтсугай:

- а) Буудлагын спортын Ази тивийн мастеруудын аварга шалгаруулах тэмцээн;
- б) “Чингис хаан-2013” жүдо бөхийн дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээн;
- в) Чөлөөт бөхийн эмэгтэйчүүдийн дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээн;



- г) Байт харвааны Азийн Гран При тэмцээн;
- д) Монгол туургатан хүүхдийн наадам;
- е) Бодибилдинг, фитнесийн залуучууд, ахмадын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн.

2. Дээрх тэмцээнүүдийг зохион байгуулахад шаардагдах зардлыг 2013 оны төсөвт тусган санхүүжүүлж, тэмцээний бэлтгэлийг бүрэн хангуулах, зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 262

Улаанбаатар
хот

Монголын Оюутны спортын III их наадам зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2013 онд Монголын Оюутны спортын III их наадмыг орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатарт, Ази, Европын оронд суралцаж байгаа монгол оюутны спортын их наадмыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатар нарт тус тус даалгасугай.

2. Спортын их наадмын анхан шатны тэмцээний зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлж, өндөр хэмжээнд зохион байгуулахыг нийслэл болон холбогдох аймаг, дүүргийн Засаг дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт, их наадмын шигшээ тэмцээн зохион байгуулахад шаардагдах зардлыг Эрүүл мэндийн сайдын 2013 оны төсвийн багцад тусгахыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт тус тус даалгасугай.

3. Монголын Оюутны спортын III их наадмыг зохион байгуулсан дүнг 2013 оны III улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 8 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 263

Улаанбаатар
хот

Журам батлах тухай, тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Дэлхийн болон бүс (тив)-ийн үс, гоо засал, хувцас урлалын мэргэжлийн тэмцээнд амжилт гаргасан үсчин, гоо засалч, хувцас урлаачид мөнгөн шагнал олгох журам”-ыг Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт болгон хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолын хавсралтад дараахь нэмэлт оруулсугай:

а) тогтоолын 2 дугаар хавсралтад дор дурдсан агуулга бүхий 4 дэх хэсэг:

“4. Дэлхийн болон бүс (тив)-ийн мэргэжлийн тэмцээн, уралдаанд онцгой амжилт гаргасан үсчин, гоо засалч, хувцас урлаачид олгох мөнгөн шагнал

Ангилал	Төрөл	Байр	Мөнгөн шагналын хэмжээ (сая. төгрөгөөр)
Дэлхийн мэргэжлийн тэмцээн	Үс, гоо засал	Гран при	40.0
		Алт	30.0
		Мөнгө	25.0
		Хүрэл	20.0
Бүс (тив)-ийн мэргэжлийн тэмцээн	Үс, гоо засал	Гран при	18.0
		Алт	15.0
		Мөнгө	12.0
		Хүрэл	9.0
Дэлхийн мэргэжлийн тэмцээн	Хувцас урлал	Гран при	40.0
		Алт	30.0
		Мөнгө	25.0
		Хүрэл	20.0
Бүс (тив)-ийн мэргэжлийн тэмцээн	Хувцас урлал	Гран при	18.0
		Алт	15.0
		Мөнгө	12.0
		Хүрэл	9.0

б) тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагийн жагсаалт”-д дор дурдсан агуулга бүхий хэсэг:

Ангилал	Төрөл	Давтамж
Дэлхийн мэргэжлийн тэмцээн	Үс, гоо засал	2 жил тутам
Бүс (тив)-ийн мэргэжлийн тэмцээн		Жил бүр
Дэлхийн мэргэжлийн тэмцээн	Хоёр. Хувцас урлал	2 жил тутам
Бүс (тив)-ийн мэргэжлийн тэмцээн		Жил бүр



3. Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл болон 2 дугаар хавсралтын “Онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд” гэснийг “Онцгой амжилт гаргасан уран бүтээлч, үсчин, гоо засалч, хувцас урлаачид” гэж, мөн зүйл болон тогтоолын 3 дугаар хавсралтын нэрний “номын яармагийн” гэснийг “номын яармаг болон үс, гоо засал, хувцас урлалын мэргэжлийн тэмцээн, уралдааны” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 26-ны
өдрийн 120 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

**ДЭЛХИЙН БОЛОН БҮС (ТИВ)-ИЙН МЭРГЭЖЛИЙН ТЭМЦЭЭН,
УРАЛДААНД ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН ҮСЧИН, ГОО ЗАСАЛЧ,
ХУВЦАС УРЛААЧИД МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь үсчин, гоо засалч, хувцас урлаачийн ур чадварын үнэлэмжийг дээшлүүлж, үс, гоо засал, хувцас урлалын салбарт өндөр амжилт гаргах идэвх сонирхлыг өрнүүлэх, олон улсын үс, гоо засал, хувцас урлалын салбарын соёлоос суралцах, шилдэг туршлагыг нэвтрүүлэх, үсчин гоо засалч, хувцас урлаачдын ур чадварыг олон улсын түвшинд таниулах, нэр хүнд, байр суурийг нь дээшлүүлэхэд оршино.

1.2. Дэлхийн болон бүс (тив)-ийн хэмжээнд зохиогддог үс, гоо засал, хувцас урлалын мэргэжлийн тэмцээн, уралдаан (цаашид “тэмцээн, уралдаан” гэх)-д амжилттай оролцож тэргүүн байр (гран при), нэгдүгээр байр (алтан медаль), хоёрдугаар байр (мөнгөн медаль), гуравдугаар байр (хүрэл медаль)-т шалгарсан үсчин, гоо засалч, хувцас урлаачийг шагнахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. Шагнах олгох

2.1. Тэмцээн, уралдаанд амжилттай оролцсон үсчин, гоо засалч, хувцас урлаач, түүний харьяалагдах байгууллага нь дараахь материалыг холбогдох баримт бичгийн хамт тухайн тэмцээн, уралдаан дууссанаас хойш 60 хоногийн дотор ахуйн үйлчилгээ, оёдлын салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх)-д ирүүлнэ:



- 2.1.1. шагнуулах тухай хүсэлт;
2.1.2. Мэргэжлийн холбооны тодорхойлолт;
2.1.3. тухайн тэмцээн, уралдааны талаархи дэлгэрэнгүй танилцуулга;
2.1.4. тухайн тэмцээн, уралдааны заавар, болзол, оролцох журам;
2.1.5. авсан шагналыг нотлох баримт, диплом, гэрчилгээний эх хувь, хуулбар;
2.1.6. иргэний үнэмлэх, гадаад паспортын хуулбар;
2.1.7. тэмцээн, уралдаанд оролцох урилга, зардлын баримт.

2.2. Төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан материалыг хянан үзээд шаардлага хангасан тохиолдолд мөнгөн шагнал олгох тухай санал боловсруулан ахуйн үйлчилгээ, оёдлын салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

2.3. Тэмцээн, уралдаанд амжилттай оролцсон үсчин, гоо засалч, хувцас урлаачид мөнгөн шагнал олгох шийдвэрийг ахуйн үйлчилгээ, оёдлын салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

2.4. Тэмцээн, уралдаанд үсчин, гоо засалч, хувцас урлаач амжилттай оролцуулсан шүүгч-дасгалжуулагч буюу түүний харьяалагдаж байгаа байгууллагад үндсэн шагналын 30-иас доошгүй хувийн урамшуулал олгоно.

2.5. Энэхүү журмын 2.4-т заасан урамшуулалтай холбогдох харилцааг гэрээгээр нарийвчлан зохицуулах бөгөөд гэрээний үлгэрчилсэн загварыг төрийн захиргааны төв байгууллага батална.

2.6. Дэлхий, бүс (тив)-ийн хувцас урлалын мэргэжлийн тэмцээн, уралдаанд амжилттай оролцож тусгай шагнал, батламж авсан хувцас урлаачид зохих шагналыг дүйцүүлэн олгож болно.

Гурав. Бусад зүйл

3.1. Мөнгөн шагналд зориулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

3.2. Мөнгөн шагнал олгоход зориулсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 14003